Хүрэлбаатар Л., Монгол орчуулгын товчоон: Сонгодог орчуулгын зарчим уран чадварын асуудалд, 1995.

<http://galaarid.blogspot.com/2006/12/2.html> (Б.Галааридын блог) “Залуу орчуулагчид өгөх зөвлөгөө-2

<http://zms.mn/> (“Зууны мэдээ” сонины цахим хувилбар: Ярилцах цаг)
Ц.Шагдарсүрэн: “Багш минь таван хүний ажлыг ганцаараа хийж явсан”, 2015.11.23

МОНГОЛ, ГЕРМАН ӨВӨРМӨЦ ХЭЛЦ ҮГЭНД МЕТАФОР (шилжмэл утга)-ЫГ ТҮГЭЭМЭЛ ХЭРЭГЛЭСЭН НЬ

А.Цэрэнчулуун⁷⁶

Товч утга: Монгол, герман хэлний өвөрмөц хэлц үгэнд метафор (шилжсэн утга)-ыг хэрхэн хэрэглэж байгаа хийгээд орчин үеийн хэлэнд түүний хэрхэн тэлж байгааг зарим нэг жишээ авч тайлбарлав.

Түлхүүр үг: амаа үдүүлэх, ганзага дүүрэн; гахай шахах, гурилдах, загалмайлсан эцэг, метафор⁷⁷, мод цагаалах, монголчлох (аргацаах); морь харах; морьтой явах (Glück haben); мөнгө угаах, мөнгөнд умбах, мөнгө уух, нийгмийн шаар, өөрийгөө ялах, тэнгэр харуулах (алах), улаан коммунист, үзүүр булаацалдах, хийморьтой (glücklich); хов базах, хуулийн цоорхой, хүний шаар, шар гозолзох, хээгээ алдах (ичихээ мэдэхгүй); царцаах, цөм хийх, цэг тавих, чирэгдэх, чөдөрлөх, шилэн данс, шордох, яс хаях.

Аливаа амьд хэл үргэлж шинэчлэгдэн баяжиж, зарим хуучин үг хэллэг цагийн аясаар гээгдэх, зарим нь шинэ утга санаа авч сэргээгдэн хэрэглэгдэх нь хэвийн үзэгдэл юм.

Түүний нэгэн адил хүний сэтгэхүй, дүрслэл, хэл яриа зүйрлэлээр баян, тэр дундаа монголчууд нүүдлийн соёлтой ард түмний хувьд байгаль орчин, байгаль, цаг уурын үзэгдэл, малчин түмний хувьд малын ааш зан, шинж төрхийг тусгасан зүйрлэлийг ардын аман зохиол, орчин үеийн утга зохиолд тусгасан нь тун их ажээ.

Монголчууд ч уламжлалт нүүдлийн мал аж ахуйн соёлтой, бас нүүдэл суудал, аян дайн, эргэл мөргөл, бадарчлал, аялалаар тив тивээр явж, олон янзын соёлтой танилцаж, өөр өөр соёлыг алгуур идээшүүлж авсны зэрэгцээ, өөрийн соёлыг ч бас түгээж явсан өвөрмөц нэгэн ард түмэн билээ. Тэр хэрээрээ ч зүйрлэлээр баян бөгөөд түүхэн тодорхой нөхцөлд нэг үе дорнын соёлтой орнуудтай, нэг үе оросын соёлтой уялдаж, соёлоо харилцан солилцож ирсэн бол эдүгээ дэлхийчлэл, мэдээллийн эрин үед баруун европ, америкийн соёлын хэл, сэтгэлгээний өвөрмөц зүйрлэл буюу метафорчлал орж ирж, хэл сэтгэлгээнд идээшиж байна.

Монгол хэл сэтгэхүйд “луу унжих” гэдэг хэлц байдаг. Говь нутагт хүмүүс хур борооны хүслэн болоод байхад үүл унжаад яах аргагүй бороо орох нь гэтэл жаахан шороо босоод үүл сарнин алга болдог. Зарим хүн хоосон горьдоогоод байж, байж амалснаа биелүүлэхгүй хүлээлгээд байхыг битгий “луу унжаад байгаарай” хэмээн

⁷⁶ Орчуулагч, судлаач

⁷⁷ Энэ нь [Латин](#) хэлний *metaphora* “зөөвөрлөх”, [грек](#) хэлний *μεταφορά* (метафора), “шилжүүлэх” гэсэн утгатай үгнээс гаралтай, утга шилжүүлэн хэрэглэх гэсэн санааг илтгэх ажээ.

дээрх утгыг шилжүүлэн хэлдэг билээ. Энэ бол хүний цаг агаарын үзэгдлийг хүний ааш занд шилжүүлэн хэрэглэж байгаа хэрэг билээ.

Метафорчлах буюу утга шилжүүлэн хэрэглэх

Метафор нь латин хэлний "metaphora"(зөөвөрлөх), грек хэлний "μεταφορά" (шилжүүлэх) гэх мэт утгатай үгнээс үүдэлтэй ажээ. Өөрөөр хэлбэл, нэг зүйлд шууд утгаар хэрэглэдэг хэллэгийг өөр нэг зүйлд шилжсэн утгаар хэрэглэхийг метафорчлах гэж хэлдэг байна хэмээн ойлгож болох мэт санагдах ажээ.

Монгол хэлэнд хэдийнээс хэрэглэсээр ирсэн шилжсэн утгатай үг хэрэглээ:

ам авах, ам алдах, ам таглах, амаа барих ганзага дүүрэн; гурилдах, мод цагаалах, морьтой явах, мөнгө уух, хор найруулах, хорхойсох, хөлжих, хужир, хээгээ алдах (ичихээ мэдэхгүй); чирэгдэх, чөдөрлөх, шар хөдлөх, шордох, яс хаях,

Социализмыг өрнүүн байгуулах үед орж хэвшсэн, шилжмэл утгатай үгс:

алаг үзэх, алтан хошуу өргөх, *арын хаалга*, биеэ барих, газар авах, гахай шахах, гурилдах, *данхраадуулах*, зүрхээ авах, мод цагаалах, монголчлох (аргацаах); *нагдааванд оруулах*, нийгмийн шаар, нуруугаа авах, *татлага*, улаан коммунист, хүний шаар, цэг тавих, чирэгдэх, чөдөрлөх г.м.

Зах зээлийн тогтолцоотой хүмүүнлиг ардчилсан нийгмийн үед монгол хэлэнд орж ирж, хэвшсэн шилжмэл утгатай үгс:

ажил хайх, ажил хаях, ажил хаях, амаа үдүүлэх, баялгийн хараал хүрэх, лоом ноосоор зүлгэж тэмнэ хийх, мессежний англи хэл, мөнгө босгох, мөнгө уух, өөрийгөө ялах, хов базах, туушиндах, хор найруулах, хорхойсох, хуулийн цоорхой, царцаах, цөм хийх, шар хөдлөх, шилний цаанаас чихэр долоолгох, шилэн данс, царцааны нүүдэл (*Wählerwanderungen*), давхар дээл, манан, хаврын синдром, цүнх баригч, шүгэл үлээгч

Эдүгээ дэлхийчлэл, мэдээллийн эрин үед гадаад харилцаа улам бүр хөгжиж, нэгэн үе хол байсан ертөнц мэдээлэл, технологийн эрин үед ойртохын хэрээр хүмүүсийн сэтгэлгээ улам бүр өөрчлөгдөн хуучин байсан үг хэлцийг өөр зүйлд шилжүүлэн өөр утгаар хэрэглэн, шинэ шинэ ойлгоц сэтгэлгээ буй болж байна. Жишээ нь өнөө цагт идэвхтэй хэрэглээнд байгаа заримаас нь дурьдвал: *загалмайлан эцэг (God father)*, *хөгжлийн өдөөгч (growth catalyst)*, *алтан боломж (golden chance)*, *санхүүгийн ертөнц (financial world)*, *матрын нулимс унагах (Krokodilstränen weinen, to shed crocodile tears)*, *“ертөнцөөс тасрах”*, *“мөнгө угаах”(Geld waschen)* зэрэг үг хэллэг нь хэдийгээр шилжсэн утгатай ч монгол төрхөнд хэдийн оржээ.



Ерээд оноос хойш дэлгэрсэн, ингэхдээ зарим нэг нь бүр өвөрмөц хэллэг (идиом) болтлоо монгол хэлэнд бэхэжсэн байна⁷⁸.

Алив үндэстэн бүхэнд өөрийн амьдрах орчин байгаль, цаг уурын нөхцөл, ахуй байдал, хэл, соёл, сэтгэлгээний онцлогтой холбогдсон олон шилжмэл утгатай үг хэллэг (метафор) байдаг байна.

Герман болон европын хэлэнд ч бас шилжмэл утгатай үг олон байх ажээ. Энэ нь техник хөгжихийн хэрээр улам баяжиж байх ажээ.

Нэгэн жишээ:

Мөнгө угаах (*Geld waschen*)⁷⁹, мөнгөнөөс өмхий үнэртдэггүй⁸⁰ (*Geld stinkt nicht*), мөнгөнд умбах (*in Geld schwimmen*), их мөнгөтэй байх, орвонгоор нь эргүүлэх (*sich um hundertachtzig Grad drehen*) хөмөрч орхих, гэмгүй царайлах (*sich die Hände in Unschuld waschen*), огтхон ч эв дүйгүй (*zwei linke Hände haben*), шавгийн гал шиг (*viel Lärm um nichts*), удаж ухаарах, (*eine lange Leitung haben*), хүртээлгүй юм ярих (*Makulatur reden*), гал дээр тос хийх (*Öl ins Feuer gießen*) ялих, шалихгүй зүйл (*ein Sturm im Wasserglas*), банзанд нь тусах (*eine Fahrkarte schießen*), хуучин тавыг ховхлох хэрэггүй (*schlafende Hunde soll man nicht wecken*).

Нэг жишээ хэлэхэд, орчин үед хамгийн түгээмэл хэрэглэж байгаа нэг шилжмэл утгатай өвөрмөц хэлц бол “мөнгө угаах” (*Geld waschen*) юм. Мөнгийг угаах гэдэг үгчлэн ойлговол ухаж мэдэхэд хэцүү юм. Ямар ч улсын цаасан мөнгөн дэвсгэртийг угаах гэдэг шууд утгаараа ойлгох боломжгүй. Зөвхөн шилжсэн утгаар ойлгогдоно. Хөдөлмөрийн бус аргаар *авлигал, хүн худалдаалах, янханчлал, хар тамхины наймаа* зэргээс олсон бохир бэлэн мөнгийг элдэв аргаар хөдөлмөрийн шударга орлогоор олсон мэт болгон дансны мөнгө болгохыг “мөнгө угаах” гэдэг байна.

Нэгэн жишээ:

seinem Affen Zucker geben (сармагчинд чихэр өгөх) монголоор бол “улам хөөргөх, дэврээх” гэсэн утга илэрхийлдэг бол *den Amtsschimmel reiten*, (албаны морь

⁷⁸ ЦАГ ҮЕ БА МЕТАФОРЧЛАХ СЭТГЭЛГЭЭ Ц.МАГСАР (МУБИС-ийн ОХУЗТэнхмийн профессор, хэл бичгийн ухааны доктор)

⁷⁹ ХБНГУ-ын Холбооны Сангийн яамны барагцаалсан тоогоор жилд 100 саяар тоологдох бохир евро угаагдаж байдаг ажээ.

⁸⁰ Мөнгөнөөс өмхий үнэртдэггүй

Энэ үгийг ромын хаан Веспасиан (МЭ 69-79) их мөнгө олохын тулд боломжтой бүх юмнаас татвар авч эхэлжээ. Бие засах газраас татвар авчээ. Хүү нь үүнд дургүйцэхэд хүүгийн хамар дор жорлонгийн татварт авсан мөнгөнөөс нэгийг бариад эндээс муухай үнэр гарч байна уу гэхэд “үгүй” гэжээ. Ийнхүү “*pecunia non olet*” (“*Geld stinkt nicht*”) мөнгөнөөс өмхий үнэртдэггүй гэсэн алдарт хэллэг гарчээ. Энэ шилжсэн утгатай үгийг зах зээлийн орны хүмүүс бүхэн хэрэглэдэг.

унах) гэдэг нь товчхон хэлэхэд “хүнд суртал гаргах”, *einen langen Arm haben* (урт гартай байх), гэдэг нь монголоор бол хэм хэмжээнээс хэтэрсэн урт гартай хэн нэгнийг хэлээгүй харин “эрх мэдэл нөлөө ихтэй хүн” гэсэн утгаар хэрэглэгдэх болой.

Герман хэлний *gut Wetter machen*⁸¹ (тэнгэр сайн болгох) аянд гарах, зугаацахаар явахад тэнгэр сайхан байвал таатай. Хэн нэгэн хүнтэй уулзах, хэн нэгнээс юм гуйхад тэр хүн сайхан зантай байвал ажил бүтэмжтэй байх нь мэдээж хэрэг. Тэгэхлээр юун түрүүн уулзах хүнийхээ ааш занг зөв хөглөх, сайхан ааштай болгохыг шилжсэн утгаар “тэнгэр сайхан болгох” гэдэг ажээ. Тэгэхдээ герман хэлний “Wetter” гэдэг үг одоо цаг агаар/тэнгэр гэсэн утгатай ч дээр үед “ааш зан” гэсэн утгыг илэрхийлж байжээ. Тэгэхлээр “*gut Wetter machen*” гэдэг үг үгчилбэл тэнгэр сайхан болгох буюу монголчилбол “тал засах” гэдэг хэллэгтэй яв цав дүйх ажээ.

Герман хэлний “*Heulen wie ein Schlosshund*” (цайзын нохой шиг ялин хуцах) цайзын хашаан дотор үргэлж ганцаараа байдаг нохой уйдаж, ганцаардан байнга улин хуцаж байдаг аж. Хэн нэгэн энгэнэтэл уйлж байвал германчууд дээрхтэй адилтгасан шилжсэн утгаар “цурхиран уйлах” -ыг хэлдэг байна.

Герман хэлний “*Jedes Wort auf die Goldwaage legen*” (үг бүрээ алт, мөнгөний дэнсэн дээр жинлэх) алт, мөнгө, эрдэнийн чулуу гэдэг асар үнэтэй учраас өчүүхэн жижиг үртэс, хэлтэрхийг ч гэсэн маш нарийн жинлүүр дээр тавьж жинлэдэг. Гэтэл хүнийг аварч ч болох, бас алж ч чадах хүчтэй үгийг “бас нарийн жинлэх” хэрэгтэй гэсэн санааг шилжсэн утгаар хэлэхийн өмнө сайтар бодож цэгнэж байж хэлэх ёстой хэмээн Мартин Лютер библийн судрыг орчуулахдаа энэхүү метафорчлолыг хэрэглэжээ.

Герман хэлний “*Jemandem die Hucke* ⁸² *volllügen*” (үүргийг нь дүүртэл молигодох) үүрэг гэдэг ямар нэгэн биетэй, бодтой зүйлийг хийдэг сав. Түүгээрээ дүүрэн юм хийгээд үүрэх юм бол маш хүнд байж таарна. Гэтэл унаж тустал, бууж мордтол хуурахыг германчууд шилжсэн утгаар үүргийг нь дүүртэл юм чихсэнтэй адилтгажээ.

Герман хэлний “*Jemandem die Würmer aus der Nase ziehen* ⁸³” (хэн нэгний хамраас өт чангаан гаргаж ирэх) хэн нэгний ам хамрыг чангааж байж, ганц нэг үг хэлүүлэхийг ийнхүү метафорчлон хэлсэн байна.

Герман хэлний “*Aus dem Stegreif* ⁸⁴” (дөрөөн дээрээс) гэдэг нь дөрөө мулталж мориноосоо буулгүйгээр хийчих гэсэн утгатай. Ямар нэгэн юмыг урьдчилан бэлтгэлгүйгээр шууд хийж орхихыг мориноосоо буулгүй, бүр дөрөө мултлалгүй хийлээ хэмээн тусгайлан ажил болгож бэлтгэхгүйгээр хийчихийг хэлнэ. Монголоор

⁸¹ Энэ хэлц үгэнд “Wetter” гэдэг үг “ааш зан” гэсэн утга илэрхийлж байгаа ажээ.

⁸² Герман хэлний *die “Hucke”* гэдэг нь хуучин цагийн үүрэг, ачаа гэсэн утгатай үг ажээ. Худал хэлж ачаа үүрүүлэх гэсэн утгатай ажээ.

⁸³ Дээр үед анагаах ухаан хөгжөөгүй байхад өвчтэй хүний хамарт өт орсноос бие нь өвдөж байна хэмээн ятгаад их сүр бадруулан хамрыг ухаад үүнийг гаргалаа хэмээн тусгай бэлдэж очсон өтнүүдээ гаргаж хаяхад тэр хүн санаагаараа бие сайжирдаг байжээ.

⁸⁴ Герман хэлний *Steg-reif* (мордох дээс) гэдэг хуучирсан үг бөгөөд төмөр дөрөө гараагүй бүр эмээл буй болоогүй байхад гогцоотой шидэмс мориныхоо нуруун дээр тохоод түүндээ хөлийнхөө өлмийг углан морддог байсан үед гарсан “дээсэн дөрөө” ажээ.

бол "балин тахил орохгүй"(огт бэлтгэлгүй, шууд) гарын үзүүрээр хийчих зүйл гэсэн утгатай ажээ.

Герман хэлний "Beleidigte Leberwurst" (гомдож орхисон элгэн хиам) гэдэг хэлц хиамын үйлдвэрийнхнээс гаралтай ажээ. Олон төрлийн хиам чанаж байхад хамгийн эхлээд түргэн болдог хиамнуудыг гаргасаар хамгийн сүүлд элгэн хиамыг гаргах хооронд элгэн хиам гомдож орхидог гэсэн хошин үг гарчээ. Ямар нэгэн юманд гомдоод "хумсаа чамласан хүүхэд шиг" урвайж хоцорсон байвал дээрхтэй адилтгадаг байна.

Германы хэлний "Damoklesschwert" (Дамоклесийн илд) хэмээх хэлц байдаг. Дамоклесийн илдний учрыг тайлбарлах аваас: Домогт гардгаар Сиракус хааны зарц Дамоклес гэж байжээ. Хаан нь түүнийг ертөнцийн хамгийн аз жаргалтай хүн хэмээн магтсанд тэр сэтгэл хангалуун байжээ. Хаан нь түүнд хаан ширээгээ шилжүүлэх бодолтой байж. Харин хаан ширээнд суулгахын өмнө нэгэн хүнд гэгчийн илдийг адууны сүүлний ганц хялгасаар оосорлон суудал дээр нь зүүжээ. Хэзээ хялгас тасран илд толгой дээр нь унахыг хэн ч тааварлаж эс мэднэ. Сиракус аз жаргал удаан үргэлжилдэггүй, алхам тутамд золгүй явдал дагаж байдаг гэдгийг мэдүүлэх гэсэн ажээ. Эдүгээ ч гэсэн хүмүүсийн толгой дээр Дамоклесийн илд савлаж байдаг ажгуу.

Германчууд "Дамоклесийн илд" -ийн шилжсэн утгаар "гай зовлон"-г илэрхийлсэн байна.

Герман хэлний "Das geht auf keine Kuhhaut" (Ямар ч үхрийн ширэн дээр багтахгүй) гэдэг хэлцийн утгыг тайлах аваас: Европод цаас хэрэглэдэг болохоос өмнө фергамент хэмээх үхрийн адсага, ямааны турсгаар хийсэн самбар дээр юм бичдэг байжээ. Нэг хүний насан туршдаа үйлдсэн нүглийг чөтгөр нэг фергамент дээр бичдэг хэмээн ярьдаг байжээ. "Хэрээс хэтэрсэн, хүлцэшгүй, зөвшөөршгүй, ичгүүргүй, үнэмшмээргүй юм" гэхийг дээрх энэхүү (энэ чинь ямар ч үхрийн ширэн дээр багтахгүй) хэмээх шилжсэн утгаар хэрэглэдэг байна.

Зөвхөн өвөрмөц хэлцэд төдийгүй танин мэдэхүй, гүн ухааны аястай ертөнцийн гуравт ч бас зүйрлэл, адилтгалыг монголчууд түгээмэл хэрэглэсэн байдаг. Тухайлбал ертөнцийн гурван цэмцгэрт монгол хүнд хамгийн ойр, байнга анзаарагддаг байгаль, цаг уурын үзэгдэл, ахуй амьдралын зүйл, хүний нүүр царайг ийнхүү хоршуулан адилтгасан байна.

Аль ч ард түмний сэтгэлгээ, өвөрмөц хэллэгт нэг юманд байдаг хэв шинжийг өөр нэг юмс үзэгдэлд шилжүүлэн хэрэглэж утга санаагаа тодотгох нь хэвийн зүйл болох саяын авсан цөөн тооны хэдэн жишээнээс харагдаж байна.

Дүгнэлт

Метафорчлах буюу утга шилжүүлэн хэрэглэх

Метафор нь латин хэлний “metaphora” (зөөвөрлөх), грек хэлний “μεταφορά” (шилжүүлэх) гэх мэт утгатай үгнээс үүдэлтэй ажээ. Өөрөөр хэлбэл, нэг зүйлд шууд утгаар хэрэглэдэг хэллэгийг өөр нэг зүйлд шилжсэн утгаар хэрэглэхийг метафорчлах гэж хэлдэг байна хэмээн ойлгож болох мэт санагдах ажээ.

Ийнхүү утга шилжүүлэн хэрэглэсэн өвөрмөц хэлц хэвшмэл хэллэг болох нь түгээмэл байдаг байна. Ийнхүү шилжмэл утгатай өвөрмөц хэлц хүн нийгмийн хөгжлийн тодорхой нэг үе шатанд хүмүүсийн сэтгэлгээний өвөрмөц хэлбэр болж орж ирэх бөгөөд мөн тухайн цаг үе нь өнгөрөхөд бас алгуур мартагдах нь олонтаа ч түүхэнд цаг үеийн ном зохиол, хэвлэлд хуучирсан үг, хэллэг болж үлдэх нь цөөнгүй. Тухайлбал, “улаан коммунист” гэдэг үг байна.

Ном зүй:

(HERMANN PAUL, PRINZIPIEN DER SPRACHGESCHICHTE, Zweiundzwanzigstes Kapitel.

Sprachmischung, z.n. Projekt Gutenberg)

Доржийн Дашдаваа, Орчуулгын найруулга зүйн бүтэц-утга зүйн үндэс,
Улаанбаатар хот, 2010

Etymologischen Wörterbuch der deutschen Sprache «von Friedrich Kluge, Berlin 2002,
Görner Redensarten Kleine Idiomatik der deutschen Sprache ...

Redensarten und ihre Bedeutung Weltbild

die schönsten Redewendungen garant

Wörterbuch Mongolisch-Deutsch Langenscheidt Verlag Enzyklopadie

Geflügelte Worte

Zitate, Sentenzen und Begriffe in ihren geschichtlichen Zusammenhang 1981

ОРЧУУЛГЫН НИЙТЛЭГ БА ОРЧУУЛГЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ

Б.Удвал⁸⁵

Abstract: *Equivalence can be said to be the central issue in translation. The House's TQA model is more appropriate for the literature translation than other models. This paper demonstrates the revised 1997, model of translation quality assessment by displaying an analysis of result of an original text and its overt translation. Universals of translation are linguistic features also there are number of features considered to translation method. These features concern simplification, explication, normalization, distinctive distribution of lexical items. And also we are trying to look for opportunities to identify the cultural translation principle by contrastive analyses of English translation and source text.*

Түлхүүр үг: *Орчуулгын нийтлэг, хураах, дэлгэрүүлэх, Жулиан Хаус, орчуулгын чанар, хэв шинж*

1.1 Хаусын дэвшүүлсэн орчуулгын чанарын үнэлгээний загвар болон ил ба далд орчуулгын хэв шинж.

Германы хэл шинжлэлч, эрдэмтэн Жулиан Хаус анх 1977 онд аливаа орчуулга үүргийн хувьд бүрэн дүйцэлтэй байхын тулд эх бичвэр, орчуулгын бичвэр хоёр утга зүйн (semantic) болон хэрэглээний (pragmatic) дүйцэлийг хангаж байх ёстой гэдэг асуудлыг дэвшүүлсэн. Тэрээр эх бичвэрийн нөхцөлт цар хүрээг (situational dimension) тодорхойлсноор түүний үүргийг тодорхойлж болно гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, эх бичвэр бүр өөр өөрийн онцлог нөхцөл байдал, хэв шинжтэй бичигддэг харин орчуулагч үүнийг зөв тодорхойлж орчуулгаа хийх хэрэгтэй. Хаус хэдийгээр орчуулгын бичвэр эх бичвэртэйгээ бүрэн дүйцэлтэй байх боломжгүй ч нөхцөлт цар хүрээ буюу хам утгаар нь орчуулж орчуулгын дүйцлийг хангах боломжтой гэж тайлбарлажээ.

Үүний үндсэн дээр тэр орчуулгын хоёр төрлийн хэв шинжийг (typology) тодорхойлсон байна. Эдгээр нь ил орчуулга (overt translation) болон далд орчуулга (covert translation) болно.

Ил орчуулга нь (overt translation) орчуулгын бүтээл гэдэг нь уншигчдад илэрхий бөгөөд эх бичвэрийн хэл, соёлтой бүрэн холбоотой байдаг. Өөрөөр хэлбэл, уншигч бүтээлийг уншиж байхдаа орчуулгаар дамжуулан харь хэлний соёлтой танилцаж байдаг тул орчуулагч эх бичвэрт байгаа соёлын ялгааг хэвээр нь хадгалан орчуулна.

⁸⁵ МУИС-ийн Завхан сургуулийн багш, докторант

Энэ хэв шинжийн орчуулга нь нийгмийн тодорхой нэг бүлэгт биш бүхэлд нь чиглэсэн байдаг бөгөөд Хаус ил орчуулгын хэв шинжийг дотор нь хоёр ангилсан байна. Үүнд:

Түүхэн бичвэрийн орчуулга: Английн Браффорд Уинсон Чөрчилийн дэлхийн 2-р дайны тухай мэдэгдэл

Тодорхой цаг хугацаанд хамаарахгүй бичвэрийн орчуулга: Урлаг уран сайхны бүтээлүүд, ёс суртахууны сургаалууд зэрэг эх бичвэрийн соёлтой салшгүй холбоотой бүтээлүүд багтдаг бөгөөд энэ хоёр хоёулаа бүтээлч сэтгэлгээний хэв шинжийг агуулдаг.⁸⁶

Ил орчуулгын хэв шинжээр орчуулагч уншигчдыг харь соёлд хөтлөх үүрэг хүлээдэг.

Далд орчуулга нь нийгмийн аль нэг тодорхой бүлэгт чиглэсэн, эх бичвэрийн хэлний соёлтой харилцан хамааралгүй, энэ хэв шинжийн орчуулга нь орчуулж буй хэлний соёлд тохируулан орчуулсан байдаг. Орчуулгын бичвэрийн хүлээн авагчид буюу уншигчид нь эх бичвэрийн уншигчидтай ижил түвшний хүмүүс байдаг.

Хаус 1977 онд орчуулгын энэ хэв шинжийг шинжлэх ухааны текст (математикийн сурах бичиг), жуулчны гарын авлага (Ньюрембергийн аялалын эмхтгэл), эдийн засгийн чиглэлийн бичвэр (ОУ-ын хөрөнгө оруулалттай компанийн ерөнхийлөгчийн хувьцаа эзэмшигчиддээ илгээсэн захидал), судалгааны өгүүлэл (Хүн судлалын судалгааны ажлын үр дүнгийн тухай өгүүлэл) зэрэг жишээ баримтуудаар тодруулан үзүүлсэн байдаг. Эдгээр жишээнээс харахад далд орчуулгад нь хэл нийгмийн онцлог, соёлын ялгаа огт байхгүй.

Тайваний орчуулга судлаач Ян Цу Ен орчуулгын энэ хоёр хэв шинжийг орчуулгын стратеги буюу арга барил гэж үзээд эдгээр арга барил стратеги нь орчуулагчид эх бичвэрийг орчуулж буй хэлэнд аль болох бүрэн дүйцэлтэй төгс буулгах боломж олгох бөгөөд энэ хоёр стратегийг орчуулагч орчуулга хийх явцдаа хамтад нь хоёуланг нь хэрэглэж болно гэж бичсэн байдаг.⁸⁷

Хаус эх бичвэр, орчуулга хоёрыг утгат хэсгүүдээр кодлон харилцан тохируулж, орчуулгыг буцаан эх бичвэрийн хэл рүү орчуулж үзсэний дараа дамжуулалтыг тодорхой хэмжүүрүүдээр үнэлэх загварыг Халлидейн бүтэц үүргийн онол, прагматикийн зарчим, Прагийн хэлшинжлэлийн дэгийн судлаачдын гаргасан бүртгэн жагсаах онол, найруулга зүй, хэл-ярианы шинжилгээний (discourse analysis) онолууд дээр үндэслэн зохиожээ.

⁸⁶ House, 2014b, p. 55

⁸⁷ <http://ir.lib.cyut.edu.tw:8080>

1.2 Жулиан Хаусын онол, зарчмын дагуу орчуулгын бүтээлд хийсэн шинжилгээ

2009 онд англи хэлнээ хөрвүүлэгдсэн С.Эрдэнийн “Өвгөн шувуу” өгүүллэгийн англи орчуулгад дээрх онол зарчмын дагуу орчуулгын чанарын шинжилгээ хийж утгат хэсэг бүрээр нь кодлон задалж эх бичвэртэй тулгаж, англи орчуулгыг буцааж эх хэлрүү нь хөрвүүлсэн.

Орчуулгын дүйцэл Хаусын тодорхойлсон хэмжүүрүүдийн түвшинд дараах байдлаар бүртгэгдсэн⁸⁸. (Эхний 29 утгат хэсгийг түүвэрлэн оруулав)

Үзүүлэлтүүд	Дүйцэл
ЗОХИОЛЫН ХҮРЭЭ (FIELD)	29 –н утгат хэсэг бүгд энэ үзүүлэлтийг хангаж байсан.
ЗОХИОГЧИЙН ЗОРЬСОН САНАА (TENOR)	29 –н утгат хэсгээс 4 утгат хэсэг дээр энэ үзүүлэлтийг хангаж чадаагүй.
АРГА БАРИЛ (MODE)	29 –н утгат хэсгээс мөн 4 утгат хэсэг дээр энэ үзүүлэлтийг хангаж чадаагүй

Энэ орчуулга нь тодорхой цаг хугацааны хамааралгүй, нийгмийн тодорхой нэг бүлэгт чиглээгүй, монгол хэл, соёлтой салшгүй холбоотой, уран сайхны төрөлд хамаарах ил /overt/ орчуулга юм. Иймд орчуулагч англи хэлт уншигчдыг эх бичвэрт илэрч байгаа монгол ахуй, монгол сэтгэлгээний соёлд хөтлөх үүрэгтэй.

Хаус энэ зарчим загвараараа англи хэлнээс герман хэл рүү орчуулсан хүүхдийн зохиолын ил /overt/ орчуулгад шинжилгээ хийж үзүүлсэн байдаг. Харин энэ зохиол нь бага насны хүүхдэд зориулсан хялбархан, соёлын ойлголт бага, богино өгүүллэг юм. Өвгөн шувуу өгүүллэгийн орчуулгад үргэлжлүүлэн шинжилгээ хийж өгүүллэгийг бүхэлд нь утгат хэсэг бүрээр нь кодлон задалж өгөгдсөн үзүүлэлтүүдийн дагуу задлан орчуулгын чанарт шинжилгээ хийсэн. Эндээс харахад тууж, роман зэрэг өгүүллэгээс том хэмжээтэй зохиолуудын орчуулгад Хаусын загвараар үнэлгээ хийхэд редакторын зүгээс нэлээд нүсэр ажил болох боловч зориод хийвэл утга зүйн (semantic) болон хэрэглээний (pragmatic) дүйцэл хангасан бүрэн дүйцэл бүхий орчуулга гарах боломжтой юм.

Хаусын тодорхойлсон орчуулгын хоёр гол хэв шинжээр орчуулгыг тодорхойлох нь хялбар тул энэ хоёр хэв шинжийн зарчмын дагуу орчуулгын чанарыг үнэлэхэд бас их боломжтой болох нь судалгааны явцад харагдаж байна.

2.1 Орчуулгын нийтлэг

Бейкерийн тодорхойлсноор орчуулгын нийтлэг гэдэг нь ихэнхдээ орчуулгын бичвэрт түлхүү илэрдэг хэлшинжлэлийн онцлог чанар юм. Орчуулгын нийтлэг гэж юу болох, түүний онцлог чанарууд, тэдгээрийг орчуулах үйл ажиллагаанд хэрхэн тусгасан талаар судлаачид дараах түгээмэл онцлогуудыг дурдсан байна.

⁸⁸ Орчуулга зүй № 06.2018 хуудас 76

Хураах (нэг санааг давтахаас зайлсхийх)

Дэлгэрүүлэх (эх бичвэрт байхгүй үг, өгүүлбэр нэмэх)

Тохируулах (Орчуулж буй хэлний онцлогт тохируулан хэлзүйн болон, тэмдэгтийн хувиргал хийх)

Хураах ба нэг санааг давтахаас зайлсхийх. (Simplification)

Блам Кулка, Левинстон нар үгийн сангийн хураалтыг үгийн тоог багасгах үйл ажиллагаа гэж тодорхойлсон байдаг. Еврей хэлнээс англи хэл рүү орчуулсан орчуулгад хийсэн шинжилгээ мөн өөр бусад хэлнүүдийн хооронд хийсэн шинжилгээнд үндэслэн Дагут (1971), Рабин (1958), Вондерли (1968), нар үгийн сангийн хураах зарчим нь орчуулагчийн эх хэлний чадамжаас хамааралтайгаар б зарчим стратегийн дагуу явагддаг гэж тодорхойлсон байдаг юм.

Эдгээр аргууд нь:

Орчуулж буй хэлнээс шууд дүйцэлтэй үг байхгүй бол ерөнхий нэр томъёог хэрэглэх.

Эх бичвэр дээрх ойлголтыг багцаалах

Түгээмэл хэрэглэгддэг ойролцоо утгатай үг ашиглах.

Эх бичвэрийн хэлний үгийн бүх үүргийг орчуулгын хэлэнд дүйцүүлэн хувиргах

Шашны үг хэллэг, соёлын онцлогтой үг хэллэг, техник технологийн нэр томъёо зэрэг нийтлэг бус үгээр илэрхийлсэн ойлголтуудыг шилжсэн утгатай үг хэллэгээр орчуулах

Хоёр хэлний хооронд соёлын ялгаа их байвал тухайн өөр үгээр илэрхийлэх

Блам-Кулка, Левинстон нарын судалгаанд дараах жишээг гаргасан байдаг. Na'ara гэдэг үг еврей хэлэнд ихэвчлэн teenager (өсвөр насныхан) гэсэн утгатай байдаг бол, англи хэлнээс еврей хэлэнд орчуулсан орчуулгад girl (охин) гэсэн утга авах тохиолдол байдаг гэжээ. (Mona Baker. ROUTLEDGE Encyclopedia of translation studies, 2001: 288) Судлаач Вандеривэра хавсарсан нийлмэл өгүүлбэрийг хураахдаа цаг заасан үйл үг бүхий гишүүн өгүүлбэрийг хураах аргын нэлээд хэдэн баримт гаргаж ирсэн байна. Энэ нь урт өгүүлбэрийг задлах, гүн утгатай хэлцийг богино яриа болгох арга юм.

Дэлгэрүүлэх ,эх бичвэрт байхгүй үг, өгүүлбэр нэмэх (Explicitation)

Блам-Кулкагийн тодорхойлсноор энэ нь тайлбарлах процессоос үүдэлтэй бөгөөд тэрээр франц хэлнээс англи хэл рүү орчуулсан орчуулгад харьцуулсан анализ хийж жишээ гарган тайлбарласан байна. Мөн түүнчлэн дэлгэрүүлэх зарчим болон уншигчдад ойлгомжтой байх хоёр нь харилцан хамааралтай зүйл юм гэж тодорхойлсон байдаг. Орчуулгын дэлгэрүүлэх зарчим нь соёл хоорондын ялгааг дамжуулахад нэн чухал талаар өгүүлээд жишээ гарган тайлбарласан байдаг. (Mona Baker. ROUTLEDGE Encyclopedia of translation studies, 2001: 289)

Тохируулах, орчуулж буй хэлний онцлогт тохируулан хэлзүйн болон, тэмдэгтийн хувиргал хийх (Normalization)

Эх бичвэрийн өгүүлбэрзүйн байрлал, цэг тэмдэг, таслалын байрлал зэргийг өөрчлөх, зарим тохиолдолд таслал, цэг зэрэг тэмдэгтүүдийг орхиж орчуулахыг хувиргах зарчим гэнэ. Мөн эх бичвэрт гарч байгаа нэр, соёлын зарим ойлголтыг үгийн сангийн түвшинд багасган хурааж, орчуулж буй хэлний хэлцээр орлуулан орчуулсан байдаг. Энэ зарчмаар Судлаач Вандеривэра герман хэлнээс англи хэл рүү орчуулсан орчуулгад нэлээд олон жишээн дээр судалгаа хийж тайлбарласан байдаг билээ.

2.2 орчуулгын нийтлэгийн зарчмын дагуу орчуулгын бүтээлд хийсэн шинжилгээ

Өмнөх ажлын адил “Өвгөн шувуу” өгүүллэгийн англи орчуулгад орчуулгын нийтлэгийн загварын дагуу дүйцэл, нийцлийн шинжилгээ хийж дүгнэлт өгөхийг зорьж ажиллаа. “Өвгөн шувуу” өгүүллэг бол монгол үндэсний соёл, монгол хүний сэтгэлгээний онцлогийг гүнзгий тусгасан бүтээл юм. Өнгөц харахад энгийн нэг хөдөөгийн өглөөний дүрслэл, хорвоогоос буцах өдрөө хүлээсэн өвгөн, хэдэн хөгшдийн хууч дурсамж мэт харагдавч унших тусам тулж ирсэн үйлийн үрийг уужуу тайван угтах монгол хүний сэтгэлгээний мөн чанарыг өгүүлдэг.

Өгүүллэгт орсон үхэлтэй холбоотой, монголын утга зохиолын хэлэнд түгээмэл хэрэглэгддэг дараах хэлц үгийн орчуулгад дээрх зарчмын дагуу шинжилгээ хийж үр дүнг харуулав.

Монгол	Англи	Зарчим
Амьдрах өдөр нь тоотой хүн	his days had been numbered	Хураах /simplification
Үүрд нүдээ аних	closed his eyes and fell into the eternal sleep	Дэлгэрүүлэх/ Explication
Хадан гэртээ харих	to return to the earth	Тохируулах/ normalization
Хойт энгэртээ гарах	to return to the dust	Хураах / Simplification
Өвгөн шувуу буцах цаг болох	the old bird has to return...	Тохируулах/ normalization
Хичнээн сайхан салж болмооргүй ертөнц боловч Гэээгтийн дуулдаг ^{шиг} өвгөн шувуу буцах цаг болжээ.	Such a wonderful world <u>that</u> I reluctantly part, <u>butlike</u> the song that Plait sang, the old bird has to return...	Тохируулах/ normalization
Жам юм хойно	Such is the nature of man’s life	Дэлгэрүүлэх/ Explication
Ямар манай монголын удам тасрахаар биш!	Our Mongolian lineage is never to be cut off, is it?	Тохируулах/ normalization

Principles of translation	Repetition	Method	Equivalence
Simplification	2	Using common level synonym	Equivalent
		Using common level synonym	Not equivalent
Explication	2	Explanation	Equivalent
		Explanation	Not Equivalent
Normalization	4	Transformation	Equivalent
		Punctuation	Equivalent

Дүгнэлт

Хаусын дэвшүүлсэн ил болон далд хэв шинжээр орчуулгыг тодорхойлж, тогтоосон үзүүлэлтүүдийн дагуу орчуулгын чанарт шинжилгээ хийснээр: Орчуулгын онолын нэг тулгуур ай болох дүйцэл (эквивалентность) ба нийцэл (адекватность) хэмээх уран зохиолын орчуулгын үнэлгээний нэн чухал үзүүлэлтүүдийг⁸⁹ хэрхэн хангаж байгааг нарийвчлан тодорхойлох боломжтой юм. Өвгөн шувуу өгүүллэгийн орчуулга нь зарим хэсэгтээ өгүүлбэрийн утгад нийцээгүй ч эхийн түвшинд дүйцсэн орчуулга болсон.

Хянган хамрын самсааны мөгөөрс нэвт гэрэлтэн шанааны нь яс арьсаа цоо татах бий гэмээр ёрдойжээ. The cartilage of his high-bridge nose and his cheekbones stuck out as if piercing through his skin.(4/4) “Хянган хамрын самсааны мөгөөрс нэвт гэрэлтэн” гэсэн 2 бүрэлдэхүүнт өгүүлбэрийн өгүүлэхүүний бүлгийг орхиж хамрын ясны мөгөөрс шанааны яс хоёр хоёулаа арьсаа цоо татах шахаж буй мэт орчуулжээ. Эх бичвэрт хамрын мөгөөрс гэрэлтсэн шанааны яс ёрдойсон гэж өгүүлсэн. Хамрын самсаа нь гэрэлтсэн байх нь үхлийн дохио гэж Монголчууд үзэх тохиолдол байдаг. Харин шанааны яс ёрдойх нь үхлийн дохиог шууд илэрхийлдэггүй.

Орчуулгын нийтлэгийн зарчмын дагуу хийсэн шинжилгээгээр Explication буюу тайлбарлан дэлгэрүүлэх зарчмаар орчуулсан өгүүлбэрүүд өгүүлбэрийн түвшинд эхтэйгээ нийцэлгүй байх ч эхийн түвшинд дүйцэлтэй тохиолдол олон бүртгэгдсэн. Normalization буюу цэг тэмдэг нэмэх, хасах зарчмаар орчуулсан өгүүлбэр болон утгат хэсгүүд дүйцэл, нийцэл аль нь сайн байсан.

Хичнээн сайхан салж болмооргүй ертөнц боловч Гэээгтийн дуулдаг шувуу буцах цаг болжээ. Such a wonderful world that I reluctantly part, butlike the song that Plait sang, the old bird has to return.

Соёлын ойлголтыг орчуулах тухай судлаачдын дэвшүүлсэн онолын олон тодорхойлолт, зарчмуудыг монгол орчуулгын онцлогт тохируулан орчуулгын

⁸⁹ Магсар. Ц. “Уран зохиолын орчуулгад тавих шаардлага: Дүйцэл ба Нийцэл ойлголтуудын тухай” Орчуулга зүй № 6 хуудас 38

чанарын үнэлгээг бүтээлчээр хийж занших нь сүүлийн үед ихэд олширч байгаа хэл эвдсэн, буруу зөрүү чанар муутай орчуулгын бизнесийг цэгцлэхэд ихээхэн хувь нэмэртэй болно.

Ном зүй:

- Аюурзана.Г Өлзийтөгс.Л (2005), Монголын сонгомол өгүүллэгүүд, УБ., Гүн паблишн
- Ариунаа. Ч, Төгөлмаа. Б, Хосбаяр. С (2015) Орчуулах эрдмийн үндэс, УБ., ХИС сургууль
- Чимэдцэеэ. М (2013), "Үгчлэх утгачлах, идээшүүлэх ондоошуулахын" шүтэлцээ, УБ., "Орчуулга зүй" МУИС, № 02
- Шүгэр. Ц. (1972) "Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг оршив", "Орчуулах эрдэм" № 05
- Элдэв-Очир. Г (2013) "Соёлын утгыг орчуулах арга зам", "Орчуулга зүй" УБ., МУИС, 2013 № 02
- Oyun-Undraa. N, (2009) "The Old bird". Mongol Survey № 22
- Mona Baker. (2001) ROUTLEDGE Encyclopedia of translation studies, New-York, <http://translations.web-3.ru/intro/equivalents/>
<https://translationjournal.net/>
- Juliane House (2014) "Translation Quality Assessment past and present" London and New York
- Claire Kramersch (1998) "Pocket Oxford dictionary" Oxford University Press, <http://ir.lib.cyut.edu.tw:8080>
- Орчуулга зүй № 4, 5, 6

ХЯТАДЫН “ГУРВАН УЛСЫН ҮЛГЭР” СОНГОДОГ ЗОХИОЛЫН МОНГОЛ ОРЧУУЛГЫН ХАРЬЦУУЛАЛ

Д.Бадмаанямбуу⁹⁰

Б.Нэргүйжаргал⁹¹

Б.Сүмбэр⁹²

Abstract: 中蒙语两个语言的翻译在文化，教育，政治，经济，社会等诸多领域发挥着重要作用，最几年来越来越多人们研究蒙汉语翻译学、翻译理论与翻译实践。另一方面，代表内蒙古人的中国蒙古人在中国语言环境和文化中生活了一段时间，觉得他们不知不觉被影响为语言，文字，生活习俗等。只要可以看到他们的汉语和蒙古两种语言翻译工作富有的历史悠久的自己独特传记。几个世纪以来一直是精选的历史长篇小说“三国演义”本小说于 1928 年 9 月首次发布。翻译学者特睦格图的蒙古语翻译在 1959 年，1973 年和 1975 年三次出版，并每次出版时明确再修改小说。翻译大师 德·包力德巴特尔再次改进出版的西里尔蒙古出版的“三国演义”长篇小说上研究了中国古代诗歌的两种蒙古语翻译对比。

Түлхүүр үг: *хятад монгол хэлний шүлэг дуулал, харьцуулсан судалгаа, орчуулга*

Удиртгал

Орчуулга гэдэг нь нэг хэлнээс нөгөө хэлрүү бүтээлчээр хөрвүүлэн бүтээх урлаг, бүтээлч үйл ажиллагаа бөгөөд бүх хэрэглэгдэхүүнийг ашиглан утгыг бүрэн төгс гаргах бүтээлч хөдөлмөрийн үр дүн юм. Эх бичиг, зохиол бүтээлийг орчуулахын тулд орчуулагч хүн эх хэл дээрх зохиол бүтээлийг өөрийн эх хэлээр мэт ойлгосон байх шаардлагатай болдог тул орчуулга хийж байгаа хэлээрээ тухайн орчуулгыг бүрэн төгс, яруу тод оновчтой илэрхийлэн гаргасан байх учиртай. Оросын ахмад орчуулагч судлаач, профессор Л.Н.Соболев “Бүх эх бичиг зохиолыг үнэн зөв орчуулах нь юуны өмнө тэдгээрийг гүн гүнзгий ухааж ойлгох, зөв ухаарахаас гадна үг, өгүүлбэр бүрийг тус тусад нь салгаж авч үзэх биш харин бүх нөхцөл байдал, утга агуулгыг үнэн зөв тодорхой ойлгомжтой илэрхийлэн гаргахын ид шид нь зөвхөн үгэндээ биш, орчуулагчийн хичээл зүтгэлээр бий болдог хэлний дадал зуршил мэдлэгийн хуримтлал юм” гэж бичсэн байдаг.

“Шүлэг” гэдэг үг нь хүний уран сайхны зорилгоор өгүүлж буй бодол санаа, сэтгэл илэрхийллийг богино, журамласан шадуудаар хэсэглэн бичээд, тусгай

⁹⁰ МУИС, ШУС, ХУС-ийн Ази судлалын тэнхим, доктор

⁹¹ МУИС, ШУС, ХУС-ийн Ази судлалын тэнхим, доктор

⁹² МУИС, ШУС, ХУС-ийн “Гадаад хэлний орчуулгазүй”-н магистр

тогтолцоо үүсгэн, тухайн хэлний бүтцийн онцлогийн дагуу тогтсон айзам хэмжээ, холбоц бүхий нугалан зохион байгуулсан шад, бадаг бүхий уянга, туульсын зохиолын бичлэгийн нэг хэлбэр мөн. В. Инжаннаши “Улаанаа ухилах танхим” романдаа “шүлэг хэмээгч дурыг дагаж төрөгдмүй... Хэрэв урам төөрөгдвөөс даруй бэрх үгүй болмуй... Шүлэг зохиох нь нэгэн зүйлийн ухаан ормуй, бичиг олноор уншсанаар болохгүй... Хүсэлтэй сонин утга уянга хэмээгч хөх үүл салхинаа хөрвөх мэт, хүний сэтгэлийг хөдөлгөж эс чадбаас хөнгөн бийрийг хөшиж юу хиймүй” гэжээ. Энэ нь шүлгийн уран санаа, онгод урамс, билиг авъяасун гол чухал үүрэгтэйг өгүүлсэн хэрэг юм” гэсэн байдаг.⁹³

Монгол хятад хоёр хэлний шүлэг дуулал нь тухайн үндэстний утга урлагийн нэгэн чухал хэлбэр бөгөөд он удаан жилийн турш хөгжсөөр ирсэн юм. Монгол хятад шүлэг дуулал нь хурц, богино шадтай үг хэллэгээр нийгмийн амьдралын ээдрээг нарийн тусгаж, яруу тод аялгуулан уншиж айзам хэмнэлийг тааруулан дуудаж болдог яруу сайхан хэлбэр юм. Шүлэгчийн уран сэтгэмж, үг сонголт, илтгэх өгүүлэмж, арга барил өөр өөрийн онцлог байдлаас тухайн шүлэг нь харилцан адилгүй өнгө аясыг илэрхийлдэг ч ерөнхийд нь авч үзвэл шүлэг нь баялаг сэтгэлгээтэй, яруу дүрслэлтэй, ил тод аялгуу сайхан хэллэгтэй, амьдлаг уран өгүүлэмжтэй байдаг. Шүлгийг орчуулахад монгол шүлгийн хэлбэр маягт үндэслэн хятад шүлгийн өвөрмөц онцлогийг хадгалах зарчмын дагуу орчуулах хэрэгтэй болдог. Үүнд:

1. Шүлгийн хэлбэр маягийг бүрэн бүтэн илрүүлэн гаргах

Энэ арга нь монгол орчуулгад түгээмэл хэрэглэгдэж байна. Хятадын эртний шүлэгт таван толгой үгийн хэмжээст шүлэг, таван толгой үгийн тасархай бадаг, дуулал, орчин үеийн чөлөөт хэлбэрийн шүлгүүд мөн ийм аргаар орчуулагдаж байна.

2. Шүлгийн агуулгад шударга хандаж, хэлбэр маягт чөлөөтэй сэтгэх

Зарим нэг шүлгийг орчуулахад тус аргыг хэрэглэж болдог. Энэ нь уг шүлгийн хэлбэр маягт өөрчлөлт хийх, шүлгийн үгийн тоог нэмж хасах, мөр бадагт өөрчлөлт хийх гэх мэт онцлогтой байдаг. Айзам хэмнэл, сүүл холболт хятад шүлгийн чухал онцлог болдог бол монгол шүлэгт бас айзам хэмнэл толгой холболт байдаг. Шүлэг орчуулахад эдгээр онцлогыг харгалзан үзэх хэрэгтэй болно. Шүлэг айзам хэмнэлтэй учраас яруу сайхан, уншихад урсам сайхан болж, уг шүлгийг орчуулах явцад шүлгийн айзам хэмнэлтэй тааруулахаас гадна хамгийн чухал нь тухайн уншигчдын онцлогт тохируулан санаанд нь хүргэх явдал юм.

Хятадын эртний үргэлжилсэн үгийн нэрт зохиолч Лүе Гуаньжүнгийн туурвисан “Гурван Улсын Үлгэр” түүхэн роман нь Хятадын эртний дөрвөн том сонгодог бүтээлийн нэг гэгддэг. XIX-р зууны монгол үндэстний их зохиолч, нэрт монгол орчуулагч Инжаннаши (1837-1892) монгол хэлнээ анх орчуулсан боловч орчуулсан эх

⁹³ Д. Галбаатар, (2012) Уран зохиол Нэвтэрхий толь, Улаанбаатар 519-520 тал.

олдсонгүй гэдгийг Тэмэгэт “Гурван улсын үлгэр”-ийг орчуулах явцдаа тухайн үеийн тэмдэглэлдээ бичиж үлдээсэн байдаг. 1928 онд Тэмэгэтийн орчуулсан эх одоогийн хамгийн эртний бөгөөд хамгийн бүрэн бүтэн орчуулгын хэвлэл болсон байна. “Гурван Улсын Үлгэр”-ийн хятад эхэд нийт 209 бадаг шүлэг орсон байдаг ба эдгээр шүлгүүд уг романд маш гүн гүнзгий ач холбогдол үзүүлсэн гэдгийг судлаачид эрдэм шинжилгээний өдий төдий өгүүллээр судлан баталгаажуулжээ.

Зохиолд их хэмжээний шүлэг дуулал оруулан хачирласны зорилго нь тухайн нийгмийн ёс суртахуунд үндэслэн хүнийг гэгээрүүлэх өөрөөр хэлбэл, шударга ёс журмыг түшиглэн зусар бялдуучийг зэмлэн буруушааж, феодал ёсны ноёрхлыг эсэргүүцэх утгыг илэрхийлсэн байна. “Гурван Улсын Үлгэр”-т сайшаах, шүүмжлэхийг хослуулсан өнгө аястай шүлэг найраг 170 бадаг орчим байгаа нь нийт шүлгийн тооны 82%-ийг эзэлсэн байдаг. Зохиолч 209 бадаг шүлгээр бүхий л зохиолоо хачирлан, шүлгээр толгой сүүлийг авцалдуулан холбожээ. “临江仙·滚滚长江东逝水” буюу “Хүрхэрэн урсах Хөх мөрний хөвөөн дэх буурал арш” гэх дууллаар эхлүүлсэн нь бүхий л зохиолын сүр жавхлантай атлаа уяруу гунигтай өнгө аясыг илэрхийлж, уншигчдыг тухайн түүхэн орчинд хөтлөн оруулж, түүхэн он цаг, орчин нөхцөлд үлгэр үйл явдлаа дэлгэрэнгүй тоочиж, нарийн хүүрнээд, “纷纷世事无穷尽，天数茫茫不可逃” хэмээх шүлгээр зохион төгсгөдөг. Зохиолын эхлэл төгсгөлийн шүлэг ам сээр золгож, нийт 209 бадаг шүлгээр бүтэн үлгэрийн айзам хэмнэлийг хөглөж чадсанаар барахгүй, бүтэц зохиомжийг ч маш товч тодорхой болгож чадсан байна.

Тус зохиолын Тэмэгэтийн орчуулсан уйгаржин монгол бичгийн хэвлэлийн эхийг хуучин орчуулга болон орчуулагч Д.Болдбаатарын орчуулсан кирил монгол бичгийн эх хэвлэлийг шинэ орчуулга хэмээн нэрийдэж хоёр монгол орчуулгын ялгаанд үндэслэн шүлгийг сонгон жишээ болгон татаж харьцуулан судалсан болно. Үүнээс зарим шүлгийг түүвэрлэн авч үзвэл:

1.

滚滚长江东逝水，浪花淘尽英雄。 是非成败转头空，青山依旧在，几度夕阳红。 白发渔樵江渚上，惯看秋月春风。 一壶浊酒喜相逢，古今多少事，都付笑谈中。	
Хуучин Хууд 1	Мэлмэлзэн цалгих Хөх мөрний уснаа Мэргэд баатарчуудын сайн мууг тунгааж дуусхав, Зөв буруу, онож алдсан бүхэн тэрүүн өргөмөгц хоосроод Хөх уулс ор орондоо түнтийлцэж Үдшийн наран хэвээр улайнам. Насжсан загасч буурал түлээч мөрний хойгийн дээр ондорсоор Намрын саран хаврын салхин лугаа ижилдэн дасавай, Нэгэн хувин амтат архиндаа баярлалцан зоогдож Эртэн эдүгээх түмэн хэргийг Энэхүү найрын зоог болгон салхин уруу тонилгомой.

Шинэ Хууд 10	<p>Мяралзан цалгилах Хөх мөрний уснаа Мэргэд баатруудын сайн мууг тунгааж дуусвай, Онож алдсан, зөв буруу тэрүүн өргөмөгц хоосроод Ор орондоо хөх уулс сүүхийлцэж Оройн наран улайнам. Настай загасчин буурал түлээчин мөрний хойг дээр Намрын саран, хаврын салхин лугаа ижилдэн дасавай, Нэгэн хувин бор дарсандаа баярлалдан халамцаад Эртэн эдүгээгийн түмэн хэргийг Энэхүү найрын зоог болгон салхин уруу тонилгомой.</p>
--------------------	---

“Гурван Улсын Үлгэр”-ийн салхийг хагалдаг “临江仙·滚滚长江东逝水” буюу “Хүрхирэн урсах Хөх мөрний хөвөөн дэх буурал арш” гэх дууллыг Мин гүрний уран зохиолч Ян Жэнь бичжээ. Тус дуулалыг уншихаар, цалгилан урсах Хөхмөрнийг бараалан зогсох буурал арш, олон зууны түүхийг эргэцүүлэн, орчлон дэлхий мөнх настай, уул ус өнийн амьтай атал үе үеийн мэргэд баатрууд ойлох давалгаа шиг л он жилийн улираанд элэгдэн одох тул эргэж буцахгүй амьдралдаа ариун сэтгэл, ууч бодлоор тавтай жаргаж явах ёстой юм бил үү гээд сүүрслэж байгаа юм шиг санаа ахуй ургаж байна. Тэгэхээр, “мэлмэлзэн цалгих” гэдэг нь уяруун эрхэмсэг өнгө аястай санагдаж, “мяралзан цалгилах” гэдэг нь харин харьцангуй хөнгөн цовоолог санагдсан болохоор “мэлмэлзэн цалгих” нь тус дуулалын санаа ахуйтай илүү зохицож байна гэж үзэв.

Жич дэвшүүлэхэд, “滚滚长江” гэдгийн “滚” гэх үгийн үндсэн утга нь “бөмбөрөх, өнхрөх” гэсэн утгатай үг юм. Усан дээр болохоор, ойлон цалгиж ширүүн урсах байдлыг заасан тул уг дуулалд “Ойлон цалгих” гэмээр юм. Энэ нь мөн арын “浪花 усан цалгиа” гэх үгтэйгээ ч илүү авцалдах байх. “是非成败” гэдгийг хуучин орчуулгад “зөв буруу, онож алдсан бүхэн” гэсэн бол шинэ орчуулгад “онож алдсан, зөв буруу бүхэн” гэж дараачийн мөрийн “ор орондоо” гэдгийг мөн урагшлуулаад толгой холбожээ. Энэ нь өгүүлбэрийн найруулгын хувьд зохимжгүй санагдсан нь “是非” нь зөв буруу, “成败” нь онож алдсан гэх утгатай хэдий ч “алдаа оноо” гэхэд л “зөв буруу” гэх утга багтаж байна гэж үзэж байна. “青山依旧在” -ийг “хөхөмдөг уулс дүнхийсэн хэвээр” гэвэл уг дууллын гунигдуу атлаа жавхлантай өнгө аясад илүү нийцэж байх мэт “几度夕阳红” гэдгийг хуучин орчуулгад “оройн наран улайнам” гэдгээс илүү утга төгс, оновчтой болжээ. “Туравдугаар мөрийг хуучин орчуулгад “насжсан загас ч буурал түлээч мөрний хойгийн дээр ондорсоор, намрын саран хаврын салхин лугаа ижилдэн дасавай” гэж “ондорсоор” гэх үг нэмсэн бол, шинэ орчуулгад “настай загасчин буурал түлээчин мөрний хойг дээр, намрын саран, хаврын салхин лугаа ижилдэн дасавай” гэсэн нь илүү урсам яруу бөгөөд эх зохиолын хэм хэмжээтэй эн тэнцсэн, тэгээд “намрын саран, хаврын салхин лугаа ижилдэн дасавай” гэдэгт “мөрний хөвөөнд он цагийг элээсээр, оршин амьдарсаар” гэдэг утга агуулж байгаа болохоор, эх зохиолын өнгө аяс, утга угуулгатай яг чив тэнцсэн орчуулга болжээ. Тус дууллын дөрөвдүгээр мөрийг хуучин орчуулгад “нэгэн хувин

бор дарсандаа баярлалдан халамцаад, эртэн эдүгээгийн түмэн хэргийг, энэхүү найрын зоог болгон салхин уруу тонилгомой.”

2.

运筹决算有神功，二虎还须逊一龙。 初出便能垂伟绩，自应分鼎在孤穷。 1-р бүлэг	
Хуучин Хууд 14	Хосгүй мэргэн цэргийн эрдэм ину хувилгаан сахиулсан мэт, Хоёр барс эгнэгт нэгэн луу дур яахин хүрмүй. Өрлөг гавьяаг анхан удаа байгуулан чадсан тул, Үхээнц ядуу байгаад учиглан зогссон ану үүний шалтгаан.
Шинэ Хууд 23	Хосгүй мэргэн цэргийн эрдэм нь хувилгаан сахиулсан мэт Хоёр барс эгнэгт нэгэн лууд яахин хүрмүй Өрлөг гавьяаг анх удаа байгуулан чадсан тул Үгээгүй атлаа төрийн баганыг тулах тавилантай ажгуу

Хожмын хүмүүс Шуань Дэ (Лю Бэй) -гийн алдар гавьяаг магтсан шүлэг болно. Тус шүлэгт, Лю Бэйгийн олноос хэтийдсэн эрдэм ухааныг магтахдаа, Жан Фэй, Гуань Июй нарыг хоёр барс гэсэн бол эрдэм ухаандаа түшиглэн Шү улсын хаан суусан Лю Бэйг луутай зүйрлэжээ. Гуравдугаар мөрийн “初出便能” гэдэг нь “хөдөлмөгц сансандаа хүрсэн” гэх утгын “анхан удаа, анх удаа” гэх хоёр орчуулгын аль нь ч тухайн шүлгийн Лю Бэйг магтсан утга санааг тэнцүү оноож чадсангүй гэж үзэж байна. Түүнчлэн дөрөвдүгээр мөрийн хоёр орчуулга өөр өөр орчуулсан байгаа нь “孤穷” үгийн утгын орчуулга нэлээд төвөгтэйд учир байна. Хуучин орчуулгад “Үхээнц ядуу” гэж орчуулсан нь Лю Бэйг магтан буй шүлэгт зохимжгүй санагдлаа. Шинэ орчуулгад “үгээгүй” гэж орчуулсан нь зөвхөн “穷” гэх үгийн утгыг гаргасан байна. Лю Бэй бага залуу насандаа өвсөн маахай худалдан амь зууж байсан гэх мэтийн намтар түүхэнд үндсэлсэн “үгээгүй, ядуу ” гэх нь буруудахгүй хэдий ч холбогдох эрдэмтэд, энэ үгний гол санаа нь Лю Бэй удам судраа залгамжлан, Лю Бангийн байгуулсан Хан улсын үргэлжлэл болох Шү улсыг байгуулж хаан суусан хойноо зүүнш дайлаар мордон Хан гүрнийг нэгтгэн захирах хүсэл нь биелсэнгүй нөхцөл байдалд оршино гэж үздэг. Тэгэхээр “хүчин мөхөсдөн ганцаардсан” гэх утгатай байж болзошгүй юм.

3.

汉室倾危天数终，无谋何进作三公。 几番不听忠臣谏，难免宫中受剑锋。 2-р бүлэг	
Хуучин Хууд 47	Ханьний төр доройтон буурч тэнгэрийн тоо дуусахуйяа Ханалыг мэддэггүй Хэ Жинь харин гурван гүн суунам, Шудрага түшмэлийн хэдэнтээ ятгахыг сонссонгүй тул Шулуун сэлмийн амтыг үзэхээс хэлтрэхгүйеэ үнэхээр бэрх
Шинэ Хууд 56	Ханьгийн төр доройтон буурч тэнгэрийн тоо дуусахуйяа Ханалыг мэддэггүй Хөзинь харин гурван гүн суунам, Шудрага түшмэлийн хэдэнтээ ятгахыг сонссонгүй тул Шулуун сэлмийн амтыг үзэхээс хэлтрэхгүйеэ үнэхээр бэрх

Тус шүлгэнд Хэ Жинь түшмэл зэрэг дэв өндөр, зориг зүрхтэй хэдий ч бусдын заль мэхэнд унаж амиа алджээ. Үүнд “无谋” гэдэг нь яг үнэндээ “ухаан салбаагүй, бодлогогүй ” гэх утгатай. Дээрх хоёр орчуулгад цөм “Ханалыг мэддэггүй” гэж орчуулсан нь “Хангийн төр” гэдэгтэй толгой холбохыг анхаарсан нэг тал байхаас гадна Хэ Жиньгийн ханашгүй ховдог санаанаасаа болж бусдад хорлогдсон нь зохиолын орчинтой утга авцалдсан орчуулга болжээ.

4.

奔腾千里荡尘埃，渡水登山紫雾开。 掣断丝缰摇玉辔，火龙飞下九天来。 3-р бүлэг	
Хуучин Хууд 57	Мянган газар довтлохуйяа тоос манан дэгдүүлээд Усныг гэтлэж уулнаа авиран бор хүдэн татуулмой, Мяндсан жолоог тас хүнтэрч хас хазаарыг хангинуулж Улаан луу гал бадруулан өндөр тэнгэрээс буунам.
Шинэ Хууд 66	Мянган газар довтлохуйяа тоос манан дэгдүүлээд Усыг гэтлэж уулнаа авиран бор хүдэн татуулмой, Мяндсан жолоог тас чивчруулж хас хазаарыг хангинуулахад Улаан луу гал бадруулан өндөр тэнгэрээс буух мэт.

Тус шүлэгт “улаан туулай” гэсэн утга бүхий Цитү хүлгийн агсам аргамаг хурдыг магтан бахдаж хувилгаан сахиусан шинжтэй болгон шүлэглэжээ. Үүнд “紫雾” гэдгийг хоёр орчуулгад “бор хүдэн ” гэж орчуулсан нь хятад соёлд “紫云, 紫雾” зэрэг дэх “紫” нь сахиусан, хувилгаан шинж бүхий өнгө аясыг заасан утга ордог болохоор, “хувилган хүдэн” гэсэн бол эх зохиолын өнгө аяст улам нийцнэ гэж үзэв. “掣断” гэдэг үгийг хуучин орчуулгад “тас хүнтэрч” гэсэн бол, шинэ орчуулгад “тас чивчруулж” гэж оноон орчуулсан нь илүү оновчтой болж, бүхий л шүлгийн хувьд ч шинэ орчуулга нь харьцангуй уран яруу өнгө аясыг илтгэсэн байна.

5.

董贼潜怀废立图，汉家宗社委丘墟， 满朝臣宰皆囊括，惟有丁公是丈夫。 4-р бүлэг	
Хуучин Хууд 65	Харгис Дүнжүө хаан ширээ булаахыг сэмээр бодолхийлж Хань улсын өвгөдийн тахилыг товрог болгон орхив, Төр дүүрэн сайд түшмэдийг цөм нийлүүлэн бодвоос Түүний дотор ганц Дингуань шяншэн ихэс эр мөн.
Шинэ Хууд 73	Харгис Дүнжүө хаан ширээ булаахыг сэмээр бодолхийлж Хань улсын өвгөдийн тахилыг товрог болгон орхив, Төр дүүрэн сайд түшмэдийг цөм нийлүүлэн бодвоос Түүний дотор ганц Дингуань ноён жинхэнэ эр хүн аж.

Тус шүлэг бол хожмын хүмүүс түүхийн гунигт байдалд харамсан халаглаж бичсэн шүлэг юм. Хоёр орчуулгын хувьд зөвхөн сүүлийн мөрийн “丈夫” гэдэг үгний орчуулга ялгаатай байна. Тус үгийн үндсэн утга нь “нөхөр” гэх боловч эх зохиолд “эр

